

Дэлхийн улсуудын нүүрсний эрэлт, нийлүүлэлт



BP Energy 2012 оны судалгаанаас үзэхэд дэлхийн нүүрсний батлагдсан нөөц 860.94 тэрбум тонн ба одоогийн хэрэглээний түвшингээр тооцвол 112 жилийн нөөцтэй байна. БНХАУ 114.5 тэрбум тонн буюу 13%, Австрали 76.2 тэрбум тонн буюу 9.2%, тус тус эзэлж байна. 2003 оны дэлхийн нүүрсний үйлдвэрлэл 5.2 тэрбум тонн байсан бол 2012 онд 7.8 тэрбум тоннд хүрч жилд дундажаар 5% өссөн байна. Өсөлтийн дийлэнх нь Ази Номхон далайн бүс нутгийн БНХАУ, Австрали, Индонез зэрэг орнуудын өсөлт байна.

	2012	2020	2025	2030	2035	2040
Дэлхийн нийт үйлдвэрлэл	8.98	9.48	9.75	9.83	9.98	10.18
Австрали	0.50	0.57	0.59	0.59	0.59	0.61
Энэтхэг	0.67	0.84	0.92	1.01	1.18	1.41
Хятад	4.26	4.62	4.71	4.67	4.60	4.49

Эх сурвалж: АНУ Эрчим хүчний мэдээллийн газар. Дэлгэрэнгүйг эндээс <https://www.eia.gov/outlooks/ieo/coal.cfm>

Дэлхийн зах зээлд нүүрсний эрэлт хэрэгцээ ирэх таван жилд тогтвортой өснө, дундаж хэрэглээ өдөрт 600 мянган тонн байна гэж [Олон улсын эрчим хүчний агентлаг](#) мэдэгджээ.

Коксжих нүүрсний тухайд нь ихэвчлэн Ази номхон далай, Хойд Америк, Евроазийн бүс нутагт тархсан байдаг ба ОХУ, БНХАУ, АНУ, Монгол, Австрали, Канад зэрэг орнууд коксжих нүүрсний нөөц ихтэй. Нүүрс үйлдвэрлэл, хэрэглээгээрээ БНХАУ дэлхийд 1-рт ордог.

Коксжих нүүрсний баяжмалыг ихэвчлэн гангийн үйлдвэрт хэрэглэдэг бөгөөд хэрэглээ нь жил бүр өссөөр байна. 2007 оны дэлхийн коксжих нүүрсний хэрэглээ 809 сая тонн байсан бол 2012 онд 976 сая тонн болж өссөн байна. Дэлхийн коксжих нүүрсний баяжмалын дийлэнх хэсгийг Ази тивийн орнууд хэрэглэдэг ба үүнээс БНХАУ хамгийн ихийг хэрэглэж байна. Хятад улсын коксжих нүүрсний баяжмалын хэрэглээ дэлхийн нийт хэрэглээний 49.2%-ийг эзлэж байсан бол 2012 онд 59.35% болж нэмэгдсэн.